

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

/ Суралцахуйн удирдамжийг удирдлага болгоно. /

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

Бүрэн дунд боловсролын ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх, мэргэжил арга зүйгээр зөвлөн туслах зорилгоор дараах зөвлөмжийг хүргэж байна.

БДБ-ын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд багш нар хөтөлбөрөө сайтар судалсан, ойлгосон байх шаардлагатай байна.

Иймд БДБ-ын хөтөлбөрийг суурийн хөтөлбөртэй холбон товч тайлбар хийе.

БДБ –ын хөтөлбөр нь зорилго, зорилт (заавал судлах, сонгон гүнзгийрүүлж судлахын мэдлэг, чадвар, хандлага), агуулга (заавал судлах, сонгон гүнзгийрүүлж судлах 10, 11, 12 дугаар анги), арга зүй, үнэлгээ гэсэн бүтэцтэй. Багш юуны өмнө хөтөлбөрийн зорилт хэд хэддүгээр ангид ямар агуулгаар хэрхэн хэрэгжих, үнэлгээний ямар шалгуураар үнэлэгдэх вэ? гэсэн хөтөлбөрийн арга зүйн холбоо хамаарлыг сайтар харж, хөтөлбөр төлөвлөлтөө хийх хэрэгтэй.

Юуны өмнө заавал судлах хөтөлбөрийн зорилтууд нь хэд хэддүгээр ангид хэрэгжихийг харьцуулалт хийж харвал: (хавсралт А)

Хүснэгтээс харахад (хавсралт А) тухайн ангид хэрэгжүүлэх зорилтын тоо тэнцүү байгаа бөгөөд эндээс багш аль суралцахуйн зорилт нь зөвхөн нэг ангид, аль нь хоёр ангид эсвэл төгстөл нь хэрэгжих вэ?, цаашлаад нэг нэгж хичээлээр үү? хоёр ба түүнээс дээш нэгж хичээл бүрээр үү? гэдгийг тооцож, хөтөлбөр төлөвлөлтөө боловсруулах хэрэгтэй болно. Хөтөлбөрийн хандлага төлөвшүүлэх зорилт нь аль ч ангид хамаарах тулд энд ялгасангүй.

БДБ-ын хөтөлбөр нь төрөл бүрийн найруулгатай эх, бичвэр мэдээлэлтэй ажиллах замаар хэл, хэлний хэрэглээг судлах, хэрэглэх арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлэх гэсэн суурь боловсролын ерөнхий арга зүйд үндэслэнэ. Жишээ нь: Тайлбарласан эсээг уншиж, сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах болон эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах замаар эзэмшсэн мэдлэг

чадвараа ашиглан олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих гэх мэт.

Агуулгын хувьд судлагдахуунд суурилсан агуулгаас (Хэлний бүтээвэр, үг, өгүүлбэр, эхийг утга, бүтэц, хувиргал, соёлын хүрээнд авч үзэх) хэлэхүйн дөрвөн чадвар буюу (унших бичих, ярих-сонсох) хэрэглээнд суурилсан агуулгад шилжсэн бөгөөд хичээлийн төлөвлөлт, багшийн заах арга зүй үүнтэй уялдан шинэчлэгдэх өөрчлөгдөх шаардлага гарна. Жишээ нь: Бид өмнө нь хэлний нэгжийг бүтцийн талаас илүү анхаарч заадаг байсан бол өнөөдөр эхийн бүхэл агуулгыг бүрдүүлж байдаг цогцолбор, өгүүлбэр, үг, бүтээврийн утгыг, цаашлаад нэг авианы ч утга үүргийг зөв ойлгох, хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд багшийн арга зүй чиглэнэ. Суурь боловсролын МХ - ний хөтөлбөрийн хүрээнд бдугаар ангиас эхэд зохиогчийн сонгосон үг хэллэг нь найруулгад хэр зохист байгаа, түүний зорилго, үүргийг тайлбарлах чадвар эзэмшихээр байгаа бөгөөд энэ нь ахлах ангид найруулгын амин сүнс болсон үг сонгох чадварын суурь болох, 10 дугаар ангид баримтад үндэслэн сэтгэгдэл мэдрэмжээ дүрслэх, хөрөглөх чадвар, мэдрэмж нь 7дугаар ангид дүрслэн бичсэн эхийг задлан шинжилж, дүгнэлт гаргах, жишээ нь: Золбаярын “Намар ай” дүрсэлсэн эхэд “Гозгор халиун ооно зээргэнэ бүүргэнэ сэрмэж хазна. Гозойж дэгээтэх хар сүүлний нь үзүүр салхин аясаар намина.” гэснээс сүүлний үзүүр “намирах” биш “намина” гэдгийг хүүхдүүд зээрийн үс тачир тул үйл үг бүтээх “р” дагавар байх байхгүйн утгын ялгаа, мөн эхэд “Сургуулийн хүүхдүүд ирэхээр сум дуутай шуутай болоод л явчихна” гэхэд дуутай шуутай гэсэн хоршоо үг, “бол” үйлийн “оод” нөхцөл, “л” баймжит бүтээвэр, “явчихна” гэдгийн “чих” байдлын дагавар зэргийн утга, үүргийг тайлбарлах гэх мэтээр хэлний нэгжийг утга талаас нь ойлгож, тайлбарлаж, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих чадварт үндэслэх зэргийг багш холбож, төлөвлөлтөө хийнэ

Суурийн хөтөлбөрт бдугаар ангид хүүрнэх, 7дугаар ангид дүрслэх, 8,9дүгээр ангид тайлбарлан бичих чадвар эзэмшихээр байгаа бөгөөд БДБ-ын хөтөлбөрт хүүрнэх, дүрслэх, тоочих, тайлбарлах, ятгах хэв маягуудыг мөн нарийвчлан судалж, хэлний чадвар эзэмшинэ. Багш монгол хэлний эхийн хэв маягийг өмнө нь зааж, ойлгож байснаас арга зүйн хувьд аль талаас нь харж, хэрхэн зааж, ямар чадвар эзэмшүүлэхийг сайн мэдэж, төлөвлөх хэрэгтэй. Жишээ нь хүүрнэн бичихэд зөвхөн цагийн дараалалтай байх гэдэг нь гол шалгуур нь биш бөгөөд хүүрнэмжид өвөрмөц шийдэл санаа бүхий зангилаа бичих, энэ нь ахлах ангид эсээ бичихэд эсээний гол

санааг агуулсан өвөрмөц, шинэ санаа бүхий хөтөч өгүүлбэр бичиж сурахын суурь чадвар болох гэх мэт.

НЭГ: ЗОРИЛГО, ЗОРИЛТ

БДБ-ын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгамдаж байгаа асуудлыг хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгээр ялгаж, тайлбар зөвлөмж бичлээ.

КЕЙС:

- Хичээлийн зорилтыг цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтод үндэслэн тодорхойлоход бэрхшээлтэй байна.
- Ээлжит болон нэгж хичээлийн зорилго, зорилтыг тодорхойлоход бэрхшээлтэй байна

Зөвлөмж 1 Багш нарын хичээлд сууж, хөтөлбөрийг үзэхэд нэгж болон ээлжит хичээлийн зорилго, зорилтыг суралцахуйн удирдамжид үндэслэн тодорхойлоход бэрхшээлтэй байгаа нь харагдаж байна.

Нэгж болон ээлжит хичээлийн зорилго, зорилтыг БДБ-ын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтод үндэслэн, агуулгын багтаамж, сэдвүүдийн хоорондын залгамж холбоо, уялдааг харгалзан тодорхойлно. Багш нарын ээлжит хичээлийн төлөвлөлтийг харахад жишээ нь “Ажлын удирдамжийг уншиж, сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ суралцахуйн зорилт нь агуулгын багтаамжийн хувьд:

- Ажлын удирдамжийг унших, ойлгох
- Ажлын удирдамжийн сэдэв, агуулгын уялдааг холбоог тайлбарлах
- Ажлын удирдамжийн бүтэц дарааллыг тайлбарлах гэсэн зорилтуудаар хэрэгжих нэгж хичээлийн зорилго байж болохыг багш тооцож төлөвлөлтөө хийнэ.

Агуулгын их бага, хүнд хөнгөн, уялдаа холбоо зэргээс хамааран тухайн суралцахуйн зорилт нь нэгж хичээлээр хэрэгжих үү?, ээлжит хичээлээр хэрэгжих үү? гэдгийг харгалзан төлөвлөнө.

Жишээ нь:

- “Тайлбарласан эсээг уншиж, сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах” - гэсэн суралцахуйн зорилтыг нэгж хичээлийн зорилго тодорхойлсон бөгөөд агуулгын уялдаагаар нь “Эхэд зохиогчийн ашигласан

баримтад дүгнэлт гаргах” дараагийн суралцахуйн зорилтыг уул нэгж хичээлийн зорилтоор авч болно. Мөн 10 дугаар ангид баримтад үндэслэн санаагаа илэрхийлэх чадвар эзэмшихэд зорих тул “Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах” энэ зорилтыг тайлбарласан эсээ буюу тайлбарласан эхэд, загварт найруулга буюу тоочсон эхэд, хөрөг найруулга буюу дүрсэлсэн эхэд ямар ямар онцлогтой байгааг судлуулж, дүгнэлт гаргах зорилгоор нэгж бүрд зорилтоор байж болох жишээтэй.

Мөн багшийн хичээлд сууж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг нь үзэхэд

- “Эхэд уран дүрслэл, хэлц, албаны үг хэллэг сонгосон зорилгыг тайлбарлах” гэсэн суралцахуйн зорилтыг нэг ээлжит хичээлийн зорилтоор авсан тохиолдол байсан. Гэтэл “уран дүрслэл, хэлц, албаны үг” - ийг ямар эхийн хүрээнд хүүхэд судалбал илүү хэрэглээтэй байх вэ? гэдгийг багш тооцох хэрэгтэй юм. Уран зохиолын эх юм уу, хөргийг задлах явцад “уран дүрслэл, хэлц” байхад “албаны үг”-ийг ажлын удирдамж, тайлангийн эхийг задлахын нэг зорилт байж болно гэх мэт.

Зөвлөмж 2 Нэгж болон ээлжитийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо тухайн сэдвийг судлах явцад суралцагч юуг мэдэх, юуг чадах, ямар ахиц өөрчлөлт гарах, хэрхэн хөгжих, төлөвшихийг харж, оновчтой, тодорхой, хэмжиж, үнэлж дүгнэж болохуйцаар тодорхойлно.

Ахлах ангид уран зохиолын эх уншихдаа хөтөлбөрийн зорилтод тодорхойлсон мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд багш анхаарч, үнэлнэ. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдэв, төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг, хэл, найруулгын онцлог гэдгийг мэдэхээс гадна тусган эргэцүүлэх, шинжлэх, тайлбарлах чадварууд буюу уншихын чадвар хэрхэн эзэмшсэнийг анги бүрд үнэлэх тул багш нэгж болон ээлжит хичээл бүрд эзэмшүүлэхийг зорьж, явцын үнэлгээ хийнэ. Хүүхдийн эзэмшсэн мэдлэг чадварыг хэд хэдэн нэгж хичээл үзсэний дараа буюу сурагч бэлэн болсон үед үнэлнэ.

Хөтөлбөрийн агуулгад туссан суралцахуйн зорилтыг эзэмшүүлэхдээ ямар үйл ажиллагаагаар чиглүүлж болох саналыг “Суралцахуйн удирдамж” гэсэн хэсгээс харж болно. Суралцахуйн удирдамжийн “Үйл ажиллагаа”-нд тусгасан үйлийн дарааллууд нь ээлжит хичээлийн чиглүүлэг байж болох ба “Үйл ажиллагаа” –аас бүгдийг биш чухлыг сонгохоос гадна сурагчдынхаа ерөнхий түвшин, өмнөх нэгжид эзэмшээгүй чадвар зэргээс шалтгаалан өөрийн арга зүйгээр өөрчилж болно.

ХОЁР: АГУУЛГА

КЕЙС:

- Тайлбарласан эсээний талаарх ойлголт болон задлал хийх арга зүйн талаар зөвлөмжилж өгөх хэрэгтэй байна.
- Уран зохиолын задлал нь өмнөх суурийн задлалаас хэрхэн ахиж буйг харуулсан арга зүйн төлөвлөлт хийж өгнө үү,

Зөвлөмж 1 Тайлбарласан эсээ буюу ерөөс эсээ бичих чадвар эзэмшүүлэхэд бэрхшээлтэй байгаа талаар багш бүр дурдаж байв. Жишиг болгож боловсруулсан жилийн төлөвлөлтөд (хавсралт А) эсээ бичих нь хүүхдээс өндөр чадвар шаардах тул тухайн нэгжийг 16 цагаар нэг нэгж хичээлээр санал болгосон.

Үүнийг хоёр нэгж хичээл болгож төлөвлөсөн ч болно. Өөрөөр хэлбэл “Эсээг уншиж, задлан тайлбарлаж, дүгнэх” “Эсээ бичих” гэсэн гэж хувааж болно. Хэрхэн төлөвлөх нь таны арга зүйн шийдэл байх болно. Эсээ бичих үйлийн баримжааг эзэмшүүлэхийн тулд тухайн суралцахуйн зорилтыг хангахуйц 4-5 эсээ задалж байж, тухайн бичвэрийн талаарх мэдлэг ойлголтыг хүүхэд эзэмшинэ гэж хичээлээ төлөвлөнө.

Нэгж хичээл сэдэв: Тайлбарласан эсээ (жишээгээр тайлбарлая.)

Зорилго:

- Олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих

Зорилт:

- Тайлбарласан эсээг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх
- Тайлбарласан эсээний сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах
- Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах
- Угсруулах үүрэгтэй бүтээвэр, холбох үгийн найруулгын үүргийг тайлбарлах
- Задалсан эсээгээ баримтаар дэлгэрүүлж бичих
- Олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих
- Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц зэргийг ашиглан илэрхийлэх

Эсээ гэж юу? гэдэг талаар мэдээлэл хангалттай байдаг тул энд дурдсангүй. (12 жилийн хөтөлбөрийн 8-12 ангийн сурах бичигт болон бусад ном гарын авлагад эсээний талаар мэдээлэл бий.) Мөн тухайн зорилтын хүрээнд хийх үйл ажиллагааны дараалал суралцахуйн удирдамжид буй тул түүнийг энд дахин ярьсангүй.

Харин эсээний үндсэн шинж, бүтцийг тодорхой эсээгээр жишээлэн тайлбарлая.

Энд Л.Түдэвийн “Хурд нэмэх жам” эсээг задлан ярилцахын зэрэгцээ 12 жилийн 12 дугаар ангийн сурах бичигт задалсан П.Батхуяг “Хурд”, Л.Түдэв “аалзны хорвоо” зэрэг эсээтэй харьцуулан тайлбарлах байдлаар зөвлөмжлөв.

- Тайлбарласан эсээг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх Аливаа эхийг унших үйл ажиллагааг сайтар төлөвлөнө. Хичээлийг ажиглаж байхад унших үйл ажиллагааг нэг удаа уншуулж, ганц хоёр асуулт асуугаад л орхиж байна. Гэтэл уншаад ойлгохын тулд бүхэл агуулгыг бүрдүүлж байдаг үг, өгүүлбэрийн утгыг нарийвчлан зөв ойлгох хэрэгтэй. Мэдээлэл хүлээн авах арга барилын тухайд яаж унших, юуг чухалчлан унших гэдгийг нарийвчлан төлөвлөнө. Эсээний гол санааг илтгэсэн үг хэллэг, зохиогчийн сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлыг илэрхийлсэн үг хэллэгийг ялгаж унших, өөрийн үзэл бодол, сэтгэгдэл мэдрэмжтэй холбох, нэгтгэн дүгнэх, үг хэлний сонголт хэрэглээ ямар байсан, зохиолчийн үзэл баримтлал, бодол санаа, бүтээлээс төрсөн сэтгэгдэл, сэтгэл хөдлөл зэргийг эхээс иш татан илэрхийлэх үйл ажиллагааг унших явцад зохион байгуулна. Эсээг уншаад хүн, нийгмийн хөгжлийн тухай эргэцүүлэн бодох, өөрийн мэдээлэл мэдлэгтэй харьцуулах, дүгнэх, тодорхой жишээ баримтаар тайлбарлах зэргээр зохион байгуулж болно.

Мөн энэ эсээг уншуулаад нийгмийн хам сэдэв буюу тухайн эсээг 1985 онд зохиосон нийгэм цаг үеийн нөхцөл байдалтай холбон багш дэлгэрүүлэн тайлбарлаж өгнө.

Тайлбарласан эсээний сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах

Эсээний бүтэц, дараалал, өрнөл, илэрхийлэх аргыг тодорхойлж өөрийн үзэл бодлыг нэгтгэн дүгнэнэ.

Эсээний үндсэн хоёр хэсгийн нэгдүгээрх нь ерөнхий буюу хүн төрөлхтний хөгжлийн хурдтай холбоотой бол, хоёрдугаар хэсэг нь тодорхой буюу монголчуудын хөгжлийн хурдыг харуулсан. Өөрөөр хэлбэл ерөнхийд тодорхойг илэрхийлж бүтэцчилсэн.

Тайлбарлан бичихэд хэд хэдэн аргыг ашиглаж болдог.

- Үйл явцын дарааллын дагуу тайлбарлах,
- Юмс үзэгдэл үйл явдлын уялдаа холбоог тайлбарлах,
- Харьцуулж бичээд өөр шинж чанарыг гаргаж тайлбарлах,
- Асуудлыг сэдэж үр дүн юм уу, зорилгыг тодорхойлох гэх мэт

Л.Түдэвийн “Хурд нэмэх жам” эсээнд “Хүн төрөлхтний хөгжлийг агуйд амьдарч байсан үеэс өнгөрсөн зуун (19дүгээр зуун), хорьдугаар зуун хүртэл, Монголын хөгжлийг энэ зууны эхнээс 1940өөд, 1985 он хүртэлх үйл явцыг цагийн дарааллаар тайлбарлан бичсэн. Мөн дэлхийн хөгжлөөс монголын хөгжил, хөгжлөөс улс орон, хүний хөгжил зэрэг юмс үзэгдэл үйл явдлын уялдаа холбоог тайлбарлан бичсэн.

Түүнчлэн цогцолбор хоорондын уялдааг харахад: Дэлхийн хөгжлийн хурдын тухайд: “Хурдлах чадварт өөрчлөлт гарсан - хурднаас айсан – эсэргүүцсэн – ойлгосон – айдсаас салсан гэсэн утгын уялдаа холбоо байхад, монголын хөгжлийн хурдын тухайд түүхийн хөгжлийн нэгэн өвөрмөц хурдыг сонгож авсан – дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн ирсэн – хурдыг өмнөхтэй зүйрлэх аргагүй болсон - монгол хүн одоо алхаж гишгэх, ярих, бичихдээ ч хурдан болсон - сэтгэн бодохын хурд бас л өссөн – дундаж нас өссөн - сэтгэлийн хурдыг давж гарах зуун” гэсэн цогцолбор хоорондын уялдааг харж болно. (энд зөвхөн тойм жишээ болгож авснаас гадна сурагчдаар өгүүлбэр хоорондын уялдаа холбоо, шалтгааныг сайтар олуулж, тайлбар дүгнэлт хийлгэх хэрэгтэй.)

Эсээнд хөгжлийн хурдыг үзүүлэхийн тулд юуг юутай харьцуулж, эндээс ямар санаа илтгэснийг сурагчдаар дүгнүүлж, ярилцана.

Нэгдүгээр хэсэг – Үйлдвэрлэлийн хөгжлийн хурдыг харьцуулсан. Жишээ нь харилцаа холбооны хурд 10 сая дахин, зорчин явах хурд 100 дахин...

Хоёрдугаар хэсэгт: Уламжлалт үйлдвэрийн хэлбэрийг орчин үеийн үйлдвэрлэлтэй, мөн цаг хугацаа орон зайг, 6 цаг явж байж ирсэн онгоц 1 цаг хүрэхгүй хугацаанд туулж байгаа онгоц, баруун аймгаас их хүрээ орсон зам, бөмбөрцгийн нөгөө бөөрөнд байгаа Нью-Йорк орох замыг түүнийг туулах хугацаатай, үйлдвэрийн бүтээмжийн харьцуулалт 40 оны турш бүтээсэн ачааг ажлын ганц өдөрт тээж байна. 5700 ширхэг тоосго цохидог байсан бол 1985 онд 30 аад мянгыг гаргадаг болсон.

Гуравдугаар хэсэгт хүн төрөлхтний хөгжлийн хурд нь хүний наслалтад урвуугаар нөлөөлж байгаа зэргийг тус тус харьцуулж гаргасан. (энд сайн тогтож ярилцах)

Эсээний бүтэц. Эсээний үндсэн бүтцийг дараах байдлаар тодорхойлдог бөгөөд үүнийг хэд хэдэн эсээгээр задалж тайлбарлах хэрэгтэй. 2014 оны 12дугаар ангийн Монгол хэлний сурах бичигт эсээний бүтэц онцлогийн талаар мэдээлэл дасгал дадлага бий. Тэнд авч задалсан хоёр эсээ нь тайлбарласан эсээ тул хичээлдээ ашиглаж болно.



Эсээний эхлэлээс сэдвийн талаар уншигчийн анхны сэтгэгдэл төсөөлөл төрнө. Уншигчийн анхаарал сонирхлыг татахад эсээний эхлэл чухал үүрэгтэй.

- Хувь хүний туршлага
- Бодит хэрэг явдлаас үүдэлтэй сонирхолтой яриа
- Сургамжтай түүх
- Алдартай хүний хэлсэн сургаал, ишлэл
- Эргэцүүлсэн хурц асуудал
- Түлхүүр өгүүлбэрийн санааг дэлгэрүүлэх баримт
- Бичиж байгаа зүйлийнхээ эсрэг санаа юм уу нөхцөлийг сонгон авах
- Сэдвийнхээ чухал болохыг уншигчид тайлбарлан
- Ямар нэгэн хэрэг явдал, товч түүх ашиглан
- Асуултаар эхлэх
- Эшлэлээр эхлэх

Хэд хэдэн эсээг хэрхэн эхэлсэн, яагаад ингэж эхэлсэн, энэ нь хэр оновчтой талаар ярилцах

Жишээ нь:

- “Хурд нэмэх жам” (Л.Түдэв) гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрээр
- “Хурд” (П.Батхуяг) гол санааг дэмжсэн зохиогчийн дүгнэлт өгүүлбэрээр
- “Аалз” (Л.Түдэв) багын дурсамжаар
- Энэ Монголын араас бүх Ази сэргэнэ. (До.Цэнджав) алдартай хүний хэлсэн үгээр гэх мэт эхлэлийг харьцуулж, уншигчийн анхаарлыг хэрхэн татаж байгаа, ямар өнгө аясыг агуулж байгаа (хошин, нөхөрсөг, шүүмжлэлт, бахадсан гм) талаар ярилцана.

Эсээний бүтцийн тухайд түүний хөтөч өгүүлбэр нь маш чухал бөгөөд хэд хэдэн эсээг задалж, хөтөч өгүүлбэрмйг олоод, яагаад хөтөч өгүүлбэр болж байгаа, яагаад хөтөч гэж нэрлэсэн, ямар үүрэгтэй талаар ярилцаж дүгнэлт гаргана,.

Хөтөч өгүүлбэр

- Эсээний эхэнд байрлаж, уг эсээ чухам юуны тухай өгүүлэх гэж буйг сэдэн мэдүүлэх зорилготой бөгөөд эсээний эхлэл цогцолбор төдийгүй, бүхэл эсээний турш чиглүүлэгч хөтөч нь болох
- Эхлэлд асуудал дэвшүүлж, уншигчийн анхаарлыг татах өвөрмөц санаа бүхий “зангилаа” хөтөч санаа
- Нэг л санаанд төвлөрсөн, өөрийн хандлага, өнгө аясыг оновчтой илэрхийлэх
- Уншигчийн анхаарлыг татаж, хөтөлж чадахуйц, үнэмшилтэй, сонирхолтой
- Хөтөч санаа нь угтаа хоёр зүйлийг тодорхойлох ёстой. Нэг нь сэдэв, нөгөө нь уг сэдвийн талаар зохигчийн хэлж буй өвөрмөц гол санаа.

Хөтөч өгүүлбэр нь гол асуудал, үндсэн санааны талаарх таны байр суурийг илтгэж буй хэсэг. Энэхүү хөтөч санаа нь энгийн нэгэн сэдэв биш, харин уг сэдэв асуудлын талаарх зохиогч юу хэлэхийг хүсэж байгааг илтгэсэн гол санааны хураангуй илэрхийлэл юм. Хөтөч санааг бичиж илэрхийлж сурах нь нэн чухал. Учир нь эсээ бичих явцад хөтөч болж, эсээгээ бүхэлд нь хянахад тусална. Өөрөөр хэлбэл хөтөч санаандаа захирагдаж түүний дагуу бичнэ гэсэн үг. Ер нь хөтөч санааг хэр зэрэг сайн тодорхойлно тэр хэрээр эсээ бичихэд хялбар болно. Хөтөч санаа тодорхой бус бол юм юм уруу орж, чухам юу хэлэх гээд байгаа нь уншигчид ойлгомжгүй байдаг. Хөтөч санаа нь эсээний сэдвийг илтгэхээс гадна уг сэдэвт хандаж буй зохиогчийн байр суурийг илэрхийлдэг.

Эсээний хөтөч өгүүлбэрүүдийг дээрх шинжийн дагуу задалж, дүгнэлт гаргах

- “Хурд нэмэх жам” (Л.Түдэв) Хөгжлийн энэ хурд сүүлийн үед өөрт нь захирагдахгүй шинжтэй болж байна. (Бусад эсээний задлал 12дугаар ангийн номд бий)

Цогцолборын гол өгүүлбэр Эсээг цогцолбороор хувааж, тус бүрийн гол өгүүлбэр болон түүнийг дэмжсэн баримтыг олж, баримт нь гол өгүүлбэрийн санааг хэрхэн дэмжиж байгааг тайлбарлах. Эндээс эсээний ерөнхий бүтцийн тухайд дүгнэж ярихад “Хурд нэмэх жам”, “Энэ Монголын араас бүх Ази сэргэнэ”, “Аалз” зэрэг эсээнүүд өмнө үзсэн бүтцийн дагуу байхад харин “Хурд” эсээ бол нэлээд өвөрмөц бөгөөд гол өгүүлбэр байхгүй хөтөч өгүүлбэрийг дэмжсэн баахан баримт байгааг ярилцах. Эндээс

эсээ бол бүтэц, зохиомжийн хувьд задгай байдаг гэдгийг ойлгуулна. Багш энд ярьж байгаа эсээгээр хаших биш үүнээс өөр бүтэц зохиомжтой эсээ олж, задалж ярилцах хэрэгтэй. Гэхдээ эсээний үндсэн бүтэц ийм байдаг гэсэн нэгдсэн ойлголтод хүрнэ.

Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах

Гол өгүүлбэрийг дэмжсэн баримт. Агуулга мөн чанарыг илэрхийлэхүйц хамгийн сонирхолтой, ач холбогдол бүхий баримтыг сонгох, баримт нь цогцолборын гол санааг дэмжсэн байх, баримтын үүрэг мөн чанар зэргийг хэд хэдэн эсээн дээр маш тодорхой ярилцана. Мөн эсээн дэх баримтын дараалал ямар байна, хамгийн ач холбогдолтой баримтаа эхэндээ эсвэл эцэстээ гэх мэт хаанаа байрлуулсан, үүний зорилго юу болохыг ярилцаж, дүгнэлт гаргуулна. (Баримтад дүн шинжилгээ хийх ажлын хуудсын санааг хавсаргав. ХАВСРАЛТ В)

Дүгнэлт хэсэг хамгийн чухал, эсээний турш хэлэх гэж байсан гол санааг хурааж бичдэг. Өмнөх ярилцсан эсээнүүдийн дүгнэлтийг хэрхэн хийснийг мөн дүгнэж ярина. “Хурд нэмэх жам” (Л.Түдэв) эсээний дүгнэлт нь “Шинээр учран золгох зуун бол бүх төрлийн юмны хурдац асар их нэмэгдэх зуун, дууны хурдыг хэд нугалан түрүүлж, гэрлийн хурдыг ардаа хийгээд сэтгэлийн хурдыг давж гарах зуун юм.

Зохиогчийн санаа нь уншигчийг дэвшүүлсэн асуудлын талаар үргэлжлүүлэн бодох, уг эсээний талаар дахин нэг сануулах явдал юм. “Хурд нэмэх жам” (Л.Түдэв) эсээний тухайд “Хурд биднийг хүлээхгүй. Хурд бол шинэ маягийн хувьсгалын гол утга, хөтөлбөргүй жам болно” гэдэг нь эсээний зохиогчийн санаа бөгөөд энэхүү санааг дээрх тодорхойлолтын дагуу хөтөч өгүүлбэртэй холбож, дүгнэлт гаргаж ярилцана. Бусад эсээг ч мөн адилаар харьцуулж зохиогчийн санааг ойлгож авна.

Эсээнд давтагдашгүй өвөрмөц санаа байх гэдэг нь эсээний гол шинж бөгөөд үүнийг мөн задалж ярилцаж буй эсээ бүртээ дүгнэж ярилцах хэрэгтэй. “Хурд нэмэх жам” эсээтэй зэрэгцүүлээд П.Батхуягийн “Хурд” эсээг задлан, харьцуулан ярилцаж болно. Хоёулаа тайлбарласан эсээ бөгөөд бүтцийн хувьд ялгаатай, санааны хувьд “Хурд нэмэх жам” эсээнд хөгжлийн хурдыг талархаж бичсэн байхад, “Хурд” эсээнд “Зул бадамлахын өмнөх гунигт бодлыг төрүүлнэ” гэх үгээр энэ их хурд хөгжил үү?, мөхөл үү? гэсэн өвөрмөц санааг гаргасан байх жишээтэй. Мөн түлхүүр өгүүлбэрийг харьцуулж болно.

“Хөгжлийн энэ хурд сүүлийн үед өөрт нь захирагдахгүй шинжтэй болж байна”, “Энэ их хурд таатай сайхан санагдахгүй л байна” гэх мэтээр ярилцах, хүүхдүүд хоёр зохиогчийн санаатай санал бодол нийлж байгаа эсэх, үгүй бол яагаад гэдгийг

баримтаар, тийм бол мөн яагаад гэдгийг баримтаар ярилцаж болно. Шинэ санаа гарган бичих гэдэг хүүхдийн сэтгэх чадварын илэрхийлэл байдаг тул түүнийг нь өдөөсөн хэд хэдэн эсээний өвөрмөц шинэ санааг тайлбарлан ярилцах хэрэгтэй.

Тайлбарласан эсээ гэдэг талаас задлан шинжлэх

- Тайлбарлах хэмээх үг нь юмны утга учрыг дэлгэрүүлэн таниулж өгөх (Я.Ц) хэмээсэн утга агуулдаг бөгөөд ямар нэгэн санааг тайлбарлан таниулах зорилготой.
- Тайлбарламж нь тайлбарлагдаж буй, тайлбарлаж буй гэсэн хоёр хэсэгтэй.

Энэ эсээнээс харахад тайлбарлагдаж байгаа юм нь “Хөгжлийн хурд” (дэлхийн болон монгол улсын хөгжлийн хурд), тайлбарлаж буй хэсэг нь эсээний гол санааг дэмжиж буй баримтууд болон зохиогчийн үзэл бодол байгааг ярилцаж болно.

Тайлбарлаж буй зүйлийн талаар судалгаатай, мэдээлэлтэй, мэдлэгтэй байж бичдэг. Тайлбарлаж бичихэд баримт ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Ерөөс эсээний үндсэн шинж бол тухайн зүйлийн талаар асар их уншиж, судалж, мэдлэг мэдээлэлтэй байхыг шаарддагийг сурагчдад задалсан эсээгээр жишээлэн тайлбарлах хэрэгтэй. Эсээнээс мэдлэг харагдаж байх ёстой гэдгийг тухайлан ойлгуулна.

Жишээ нь: Бидний жишээ болгож буй “Хурд нэмэх жам” эсээнд дэлхийн болон монголын сүүлийн 100 - аад жилд асар хурдан нэмэгдсэн хөгжлийн хурдцын талаарх баримт, мэдээллийг ялган тоочуулж, дүгнэлт гаргаж болно.

Уншигчид нөлөөлөхүйц сайн тайлбар нь шинэ мэдээллийг ойлгомжтойгоор алхам алхмаар өгч (эхний өгүүлбэрт ямар нэгэн мэдээлэл байхад дараагийн өгүүлбэрт түүний талаар лавшруулан тайлбарлах гм) зохиогч өөрийн зүгээс мэдээлэл ба тайлбарыг уншигчтайгаа хуваалцаж байгаа маягаар бичих, уншигчид шинэ мэдээллийг хүргэхдээ бичвэр доторх мэдээллийг логик дараалалтай байрлуулах зэргийг эсээнээс сурагчдаар тайлбарлуулна.

Тайлбарласан эх нь ЭНЭ НЬ ИЙМ ЮМ БАЙНА гэдгийг тайлбарлаж, уншигчдад ТИЙМ ЮМ БАЙНА гэсэн бодол санал төрүүлдэг ба эхлээд хэлэх гэсэн гол зүйлээ бичээд, дараа нь түүний үндэслэл, агуулгыг задалж тайлбарлах найруулга голлоно.

Тайлбарлан бичих явцдаа зарим үед зохиогч үе үе сэтгэл хөдлөлийн аястай дүрслэл ашиглаж бичих нь уншигчийн сонирхлыг татаж, өөрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх зорилго агуулдаг байна. Нэг зүйлийг нөгөөтэй харьцуулж тайлбарласан харьцуулал байна гэсэн үг. Хоёр зүйлийн ижил ба ялгаатай талыг жишиж харьцуулж бичдэг.

Зөвлөмж 2 Уран зохиолын сургалтын арга зүйн тухайд: Цөм хөтөлбөрийн 10 дугаар ангийн агуулгад буй шинэ болон хүнд ойлголтуудыг сайн мэдсэнээр суралцахуйн зорилтын цаад мөн чанарыг ойлгож, ээлжит хичээлээ оновчтой төлөвлөж, сурагчийн хийх үйл ажиллагааг зөв, тодорхой чиглүүлэх юм. Тухайлбал, цөм хөтөлбөрийн “Унших” агуулгын хүрээнд уран зохиолын эхийг уншихдаа найман үндсэн суралцахуйн зорилтыг дэвшүүлэн тавьсан бөгөөд зорилт бүрийн цаана утга зохиолын онолын суурь ойлголт, хандлага байна. Ахлах ангид ямар ямар шинэ ойлголт байгааг багш судалж мэдэхээсээ өмнө суурь боловсролын уран зохиолын агуулгаас хэрхэн ахиж байгааг олж харан, хүүхдийн эзэмших чадварыг хөгжүүлэхийг зорих нь зүйтэй. Хялбарчлан ойлгох үүднээс хүснэгтээр агуулгын залгамж холбоо болон мэдлэг, чадварын гүнзгийрэл, ахицыг үзүүлье.

<i>Зохиолыг хэрхэн задлан шинжлэх вэ?</i>	
<i>Суурь боловсрол</i>	<i>Бүрэн дунд боловсрол</i>
Өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын шугамыг тодорхойлох, тайлбарлах	Өгүүлэгдэхүүний бүтэц + хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах
Дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарал зэргийг тодорхойлох, тайлбарлах, дүгнэх, үнэлэх	Дүрийн бодит ба хийсвэр шинж, хэв шинж, нийтлэг шинж, бодгаль шинж, сэтгэлзүйн шинжийг тодорхойлох, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах
Орчин, нөхцөл байдлыг тайлбарлах	Орчин нөхцөл байдал + дотоод орчин буюу дүрүүдийн хоорондох харилцааны уур амьсгалыг тодорхойлох
Зохиолчийн үгийн сонголт, уран дүрсэлсний шалтгааныг тайлбарлах \хэл найруулгын талаас\	Үгийн сонголт \хэлний хэрэглээ\, уран дүрслэл + бичил дүрслэл, яруу хэрэглүүрийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах
Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлох, тайлбарлах	Сэдэв + утга санаа, хам сэдэв, далд утгыг тайлан тайлбарлах

Тодруулсан үгс бол зөвхөн багшийн хувьд зайлшгүй мэдэх онолын ойлголт, мэдлэгийг зааж байна. Суурь боловсролд сурагчийн мэдэх зүйл гээд үнэлэхгүй, харин бүрэн дунд боловсролд хөтөлбөрийн зорилт буюу 1.3-т¹ заасан мэдлэгийг л үнэлнэ.

Сэдэв – Зохиолд хөндөгдсөн асуудал

Утга санаа – Сэдвээр дамжиж уншигчдад төрж байгаа ойлголт

Хам сэдэв - Эхүүдийн хам сэдвийн нөхцөл болон бичвэртэй холбогдож буй уншигч сонсогчдын хийж буй “бичвэр хоорондын шинж”-ийг “intertextuality” чухалчилдаг.

- Соёлын хам сэдэв
- Шинжлэх ухааны хам сэдэв
- Намтрын хам сэдэв
- Нийгмийн хам сэдэв
- Улс төрийн хам сэдэв
- Эдийн засгийн хам сэдэв г.м.

Хүүрнэл - Хүүрнэлийн дотоод дох эмх цэгц ба дараалал \sequince\, “хүүрнэлт байдлын” зэрэг хэмжээ хэрхэн боловсронгуй болсныг судлахаас гадна уран зохиолын өгүүлэгчээр нь хөөж өгүүлэмжийг нь тогтоох, хүүрнэл дэх утга санаа буюу үзэл бодлын өнцөг \viewpoints\, ялгаатай дуу хоолой \voices\ -г чухалчилдаг. Мөн зохиолын дотор зохиолч хэддүгээр биеэс, хэний дуу хоолойгоор ярьж буйг шинжилнэ. Зохиогч өөрийнхөө дуу хоолойгоор, заримдаа баатрынхаа дуу хоолойгоор ярьдаг. Хүүхэд зохиолыг уншаад өөрийн байр сууринаас үнэлэлт, дүгнэлт өгөхөд энэ онол тусална.

Дүрийн бодит ба хийсвэр шинж – Дүрийн түүхэн ба уран сайхны тал

Дүрийн нийтлэг шинж – Нийгмийн тодорхой нэг үеийн олон хүнд байдаг зан чанар шингээснийг хэлнэ.

Дүрийн хэв шинж – Нийтлэг дүрийн дээд шат. Олон худалдаачны шинж байдлаас нэг худалдаачны зан чанарыг онцлон дүрсэлснийг хэлнэ. /А.М.Горький/ Нийтлэг үнэт зүйлсийг шингээсэн дүр

Дүрийн бодгаль шинж - Бусдаас ялгарах өөрийн гэсэн давтагдашгүй зан чанартай дүр

Зохиолын гадаад орчин /setting/ - Үйл явдал өрнөж буй газар орон

Зохиолын дотоод орчин /ситуаций, атмосфер/- Зохиол дахь үйл явдал өрнөх, өрнөж буй нөхцөл байдал, дүрүүдийн хоорондох харилцааны уур амьсгал

¹ Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр “Монгол хэл бичиг, уран зохиол”, 2016 он, 25-р хуудас

Бичил дүрслэл – \Detail\ Нарийн ширийн дүрслэл. Уран зохиол дахь дүр дүрслэлийн хамгийн бага хэмжээний нарийвчилсан бичлэг. Үг түүний утга, холбоосоор дамжсан зохиолчийн зорилго нь бичил дүрслэлүүд илэрнэ.

Яруу хэрэглүүр – Найруулга зүйн ур маягууд, өгүүлбэрзүйн ур маягууд²

Далд утга /implicit meaning/ - Уран дүрслэлийн цаадах санаа, хам сэдэвтэй холбоотой илрэх санаа

Тайлан тайлбарлах /интерпритация/ - Уншигч өөрийн үзэл бодлоор хандах, зохиолчоос өөрөөр сэтгэж илэрхийлж болно. Ойлголтын тухай сургаал, бичвэрээс зохиогч руу судлах ухаан. Хувь хүний төсөөлөл, мэдрэмж, боловсролоос шалтгаална. Зохиолчийг ойлгох үүднээс зохиолын ил, далд утга, үг, хэлд анхаарлаа хандуулж, нэг бүрчлэн мөрдөж унших хэлбэр. Олон тайлбар- үнэ цэн юм. “Хэл бол тоглоом” гэж үздэг.

Зохиолын бүрэлдэхүүн хэсэг – Өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын шугам, дүр, үйл явдал өрнөх орчин, нөхцөл байдал, хэл найруулга, дүрслэл, яруу хэрэглүүр, сэдэв, утга санаа, хэм сэдэв

Онолын ойлголтыг жишээн дээр тайлбарлая.

Багш нарын хичээлийн төлөвлөлтөд сэдэв, хам сэдвээ сайн ялгаагүйгээс, цаад онолын ойлголт нь бүрхэг байгаагаас шалтгаалж, Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлэгт найр наадмын хам сэдэв илэрч байна гэж үзсэн тохиолдол гарч байна. Иймээс тухайн шүлэгт найр наадам гэдэг бол Монголчуудын зан үйл ч гэдэг юм уу хөндөж тавьсан асуудал байхгүй тул сэдэв гэж үзэхгүй юм. “Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах” суралцахуйн зорилтын хүрээнд ажиллахдаа жишээ нь, Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” зохиолын эхний өгүүлбэрт анализ хийхдээ “Зохиолч хэний дуу хоолойгоор үйл явдлыг эхлэв?, Гол дүрүүдийг хаана уулзуулж байна вэ? Ямар зорилгоор Гандан дотор юм уу дэнж дээр гээгүй Гандангийн наад хүр лүү буулгаж ирэв? Тунуулах гэсэн үйл үгийн утга нь хүр лүү бууж ирэх нөхцөл байдалтай уялдаатай болов уу?, Хүүхнийг яагаад шавартай гудамжнаас гарч ирэв гэж бичсэн юм бол?” гэсэн асуултаар зохиолчийн нийгмийн талаарх, бурхны шашны талаарх үзэл бодлыг \viewpoints\ эргэцүүлж, тайлан тайлбарлуулж ярилцаж болно. Тайлан тайлбарлах буюу интерпретация хийх үйл ажиллагааг ахлах ангийн хөтөлбөрт шинээр тусгасан болно. Хүүхэд зохиолыг

² Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр “Монгол хэл бичиг, уран зохиол”, 2016 он, 66-р хуудас

уншаад өөрийнхөөрөө юу гэж тайлж байгаа нь чухал тул тухайн хичээлийн зорилгыг “Далд утгыг тайлан тайлбарлах” гэж тодорхойлсон л бол хүүхэд тайлж тайлбарлахдаа өөрийн үзэл бодлыг тусган ярьж, ярихдаа тод, чанга, ойлгомжтой, харилцагчийнхаа онцлогт тохируулан ярих зэрэг “Ярих чадвар”-ын зорилттой холбон үнэлэх учиртай. Багш зохиолын талаар дүгнэлт өгөхийг гол болгохгүй гэсэн үг. Тухайлбал, Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” зохиолд “улаан шарыг тунуулсаар” гэсэн үг хэллэгийн сонголтыг ажиглуулахдаа зохиолчийн зорилготой холбон “Чи юу гэж бодож байна вэ?”, “Зохиолч яагаад хувцасны өнгийг онцолж дүрийг тодруулж бичив?”, “Яагаад тунуулсаар гэж бичив?, Тунах биш тунуулах гэсэн утгыг “-уул” буюу бусдаар үйлдүүлэх нөхцөлийг ямар зорилгоор авч хэрэглэсэн юм бол? Энэ нөхцөлийн найруулгын үүрэг юу вэ?” гэсэн асуултаар чиглүүлж, тайлан тайлбарлуулж болох юм. Хүүхэд бүр өөрийн хандлага, туршлагаар асуудалд хандах тул багш хүүхдийн хандлагыг таних боломж үүснэ. Зохиолч чухам ингэж бичсэн гэж багш тулгахаасаа илүү судлаачдын сонирхолтой дүгнэлтүүдийг уншуулж, анализ хийлгүүлж болно. Д.Нацагдорж судлал Монголын утга зохиолд сайн хөгжсөн тул эрдэмтэн Д.Содном, Л.Балдан, С.Лочин, Ч.Жачин, Д.Отгонсүрэн нарын судалгааны бүтээлийг сурагчдад санал болгож болно. Ялангуяа хэл найруулгын талаас Ч.Жачин “Д.Нацагдорж”, Д.Отгонсүрэн “Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулгын онцлог”, “Үгийн сангийн найруулгын үүрэг” бүтээлүүд дунд сургуулийн заах аргад чухал хэрэглэгдэхүүн болно.

ГУРАВ: АРГА ЗҮЙ

КЕЙС:

- Монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын нэгдмэл хөтөлбөрийг хэрхэн боловсруулах нь ойлгомжгүй, бэрхшээлтэй байна.
- Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлээр сурагчдын мэдээлэлтэй ажиллах арга барилыг хэрхэн хөгжүүлэх, төлөвлөх талаар арга зүйн зөвлөгөө авъя.

Зөвлөмж 1. Юуны өмнө монгол хэл, бичиг, уран зохиолын цөм хөтөлбөрийн нэгдмэл агуулгаар нэгдмэл хөтөлбөр, төлөвлөгөө хийх асуудал маш ойлгомжгүй бэрхшээлтэй байна гэсэн саналыг нийт багш хэлж байна. Иймээс санаа өгөх үүднээс төлөвлөлтийг боловсруулж илгээж байна. (хавсралт1 Жишиг тул багш заавал дагах шаардлагагүй.) Хөтөлбөрийн төлөвлөлтөөс суралцахуйн зорилтыг хэрхэн агуулгын дидактик нэгжид хуваасан, нэгжүүдийн дараалал, агуулгын бүтэц тэдгээрийн уялдааг сайтар

ажиглаарай. Мөн монголхэл, бичиг, уран зохиолын хичээл нь нэгдмэлээр хэрхэн орж болохын жишээг “Хөрөг”найрууллын төлөвлөлтөөс хараарай.

- Хөрөг найрууллыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх
- Хөрөг найрууллын сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах
- Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах
- Хөрөг найрууллын уран дүрслэл, хэлц, яруу хэрэглүүрийн уншигчдад үзүүлэх үр нөлөөллийг тайлбарлах
- Хөрөг найрууллын гадаад ба дотоод орчин нь баатрыг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох
- Зохиолын найруулга нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох
- Зохиолын хэлний хэрэглээ, уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах
- Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ баримтад тулгуурлан дүрслэн бичих
- Идэвхтэй хэрэглээ бүхий үгсийн үндэс, залгаврыг үндэсний бичгээр зөв бичих
- Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, уран дүрслэл зэргийг ашиглан илэрхийлэх

Суурь боловсролын цөм хөтөлбөрөөр сурагчдад мэдээлэлтэй ажиллах арга барил эзэмшүүлэх зорилготой ч багш нарын хичээлийг ажиглахад аливаа эхийг уншуулахдаа шууд уншаарай гэхээс яаж? гэдгийг нь төдийлэн анхаарахгүй, түгээмэл дутагдал байна. Суурийн хөтөлбөрийн арга барил хэсэгт эхийг хэсэгчлэх, гүйлгэх, нарийвчлах, түүвэрлэх зэргээр унших гэж заасан. Багш сурагчдын хэрэглэж дадаж байгаа унших арга барилыг ажиглан, тэмдэглэл хөтлөх, ямар арга барил хэрэглэх нь үр дүнтэй байгаад дүн шинжилгээ хийх нь сурах арга барилыг эзэмшүүлэхэд чухал юм. Унших арга барил эзэмшүүлэх талаар суурийн цөм хөтөлбөрийн багшийн номд дэлгэрэнгүй өгүүлсэн тул тэндээс харах боломжтой. Унших үйл сурагчдыг уншсан эхээ сайтар ойлгуулахад чиглэх бөгөөд зөвхөн нэг удаа уншаарай гэснээр энэ зорилго хангагдахгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Багш нарын хичээлийн үйл ажиллагаанаас бас нэг анхаарах асуудал нь яаж гэдэг нь байхгүй унш гэдэгтэй адил, мөн яаж гэдэг нь байхгүй бич, юуг гэдэг нь тодорхойгүй бичсэнийг нь “сайн байна” гээд багш сурагчгүй “үнэлэх” тохиолдол түгээмэл байна. Суурийн цөм хөтөлбөрийн бичих арга барилыг багш нар төдийлэн үйл ажиллагаа болгохгүй байна.

Мөн нийтлэг анхаарах зүйл бол багш нар суралцахуйн удирдамжийг уншихгүй, арга зүйн санаа авахгүй байгаа нь харагдаж байна. Сурах бичиг, багшийн ном байхгүй үед

суралцахуйн удирдамж танд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг болно гэдгийг санаж, сайтар судлан, өөрийн арга зүйд уяж, сургалтаа зохион байгуулах хэрэгтэй.

Багш нар жилийн төлөвлөлтөө хийхдээ агуулгын залгамж холбоо, өргөсөл гүнзгийрэл, эзэмших мэдлэг, эзэмших чадвар, хандлага, мэдээлэлтэй ажиллах арга барил эзэмшүүлэх ерөнхий зарчим зэрэгт үндэслэн агуулгыг дидактик нэгжид хуваан төлөвлөх хэрэгтэй. Жишиг хувилбарт нэгжийн нэрийг хэрхэн өгснийг ажиглахаас гадна нэгж бүрд унших, ярих, сонсох, бичих, хэлзүйг хэрэглэх чадвар буюу суралцахуйн зорилтыг сонгохдоо уран зохиолын бус эх, уран зохиолын эхийн бичлэгийн онцлогийг харгалзана. Жишээ нь, нэгж хичээл 3-ын төлөвлөлтийг харъя. Сонгосон хөрөг найруулал нь уран дүрслэлтэй, дүрсэлсэн гол баатрынхаа /дүрийн/ бодит шинжийг тодорхой илэрхийлж бичсэн бол тухайн нэгжийн унших гэсэн хэсэгт монгол хэлний хичээлээр эзэмших чадвараас гадна уран зохиолын “Уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлбарлах”, “Дүрийн бодит шинжийг тайлбарлах” гэсэн суралцахуйн зорилтыг сонгон оруулж болно. Сонгосон эхийн бүтэц, хэллэг, найруулгын хэв маяг, үгийн сонголт чухал юм. Зарчим нь нэгдмэл хөтөлбөрөө төлөвлөхдөө унших, ярих, бичих чадвараар нь холбох зарчмыг баримтална. Монгол бичгээр унших чадварыг уран зохиолын бус, уран зохиолын эх унших хэсэгт интеграцчилж холбож болно. Мөн бичихийн тулд унших, ярих гэсэн логик холбоог сайтар анхаарна. Сонгосон эхээсээ шалтгаалаад ямар суралцахуйн зорилтыг сонгон нэгж хичээлийг төлөвлөх вэ? гэдэг нь чухал юм. Эсвэл суралцахуйн зорилтод нийцүүлэн эхээ сонгоно.

Зөвлөмж 2 Хөтөлбөрийн арга зүйд сурагчид ярих болон бичих чадвар эзэмшихийн тулд эхийг уншиж, задлан шинжилж, дүгнэлт гарган, тэндээс эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан ярьж бичихээр тусгасан. Зөвлөн туслах болон үндсэн сургалтын үед багш нарын төлөвлөлтийг харахад хичээлийн зорилтыг эхийг унших, задлахаар авсан боловч үйл ажиллагааны явцад бичих үйл хийх ба бичих зорилт тавиад задлах үйл ажиллагаа хийх, эсвэл мэдээлэл боловсруулах буюу унших, задлан шинжилж, дүгнэлт гаргах, бичих, ярих үйл ажиллагааг нэг цагт орохоор төлөвлөх нь түгээмэл байна. Нэгж хичээлийн эцсийн үр дүн бичих бол зорилго нь бичихээр, харин уншиж, задлах бол зорилго нь уншиж, задлахаар байна гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хичээлийн зорилгоо тодорхой болгох, үйлийн алхмыг зорилго, зорилт руу чиглүүлж, тодорхой болгохоос гадна багш сурагчдын ярих, сонсох чадвараар дамжуулж

харилцах, харилцааны чадварыг эзэмшүүлэх, унших, бичих чадварын холбоо уялдааг ойлгож байж, хичээлийн үйл ажиллагааг чиглүүлнэ. Мөн суралцахуйн удирдамжаа маш сайн судалж унших, ойлгомжгүй зүйл байвал онлайн сургалтаар холбогдож тодруулах шаардлагатай. Түүнчлэн хүүхдэд боломж олгох, хүүхдийн оролцоог дэмжих чиглүүлэг хэрэгтэй. Тухайлбал, “Монголын Нууц Товчоо” зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх” гэсэн суралцахуйн зорилтыг 40 минутад төлөвлөсөн хичээл байна. 40 минутад “Тусган эргэцүүлэх, илэрхийлэх” гэсэн хоёр чадварыг эзэмшүүлэх, дүгнэхэд бэрхшээлтэй тул том хэмжээний зохиолыг уншуулах эхний хичээлийг “Сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх” зорилготой гээд, хоёр дахь хичээлд “Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх” гэсэн зорилго тавина. Хэрвээ сурагчдыг “Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, илэрхийлэх” чадварыг сайн эзэмшлээ гэж үзэж, сурагчид ч өөрийн үнэлгээ хийсэн тохиолдолд дараа дараагийн нэгжийн доторх унших цагийг хасаж болох юм. Хам сэдэв гэдэг их өргөн ойлголт тул хүүхдэд цаг гаргаж унших хугацаа хэрэгтэй. “Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх” зорилготой хичээлийг дараах үйлийн алхмаар чиглүүлж болно. Жишээ нь, “Монголын Нууц Товчоо” зохиолын жишээн дээр:

1. Түүхийн ямар ямар үе гарч байгааг тэмдэглэх, яаж дүрсэлснийг жишээ баримтаар тайлбарлах
2. Зохиолд нүүдлийн соёл иргэншлийн талаар өгүүлсэн хэсгийг олж тэмдэглэх, соёл иргэншлийн талаар санал солилцох
3. Бөөгийн шашны зан үйлтэй холбоотой үйл явдлын талаар ярилцах, эргэцүүлэх, жишээ татах
4. Цэрэг дайн бодлого хэрхэн туссаныг ярилцах, Чингисийн байлдан дагуулалтын сайн талыг эргэцүүлэх
5. Монголчуудын эдэлж хэрэглэж байсан эд зүйлсийг тэмдэглэх, үнэлэлт өгч эргэцүүлэх

Багш дээрх сэдвийн хүрээнд эргэцүүлж чадаж байгааг үнэлэхдээ дараах зүйлийг анхаарна. Логик сэтгэлгээг хөгжүүлэхдээ “эргэцүүлэн бодох /*Reasoning*/, тунгаан бодох, шүүн бодох” гэсэн үйлдлийг анхаардаг байна. Эргэцүүлэх чадварыг үнэлэхдээ сурагчид олон талаас нь харж чадаж байна уу, үнэн худал, зөв буруу, хэрэгтэй хэрэггүйг ялгаж, өгөгдсөн мэдээллээс мөрдөлгөө дүгнэлт гаргаж чадаж байна уу гэдгийг харна. Иймээс багш “Нүүдлийн соёл иргэншлийн эерэг болон сөрөг тал юу

байна? Монголын Нууц Товчоо зохиолд яаж тусав? Шашны зан үйлээс болж хэн буруудав? Шашныг дагаж мөрдсөнөөр сайн зан үйл юу гарав? гэх мэт сэдэлжүүлэх асуултаар чиглүүлж болно. Харин асуултын хариултад хэт анхаараад юуг үнэлэх вэ гэдгээ орхигдуулахгүй байхыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл эргэцүүлж ярьж байгааг үнэлэх нь монгол хэл, уран зохиолын хичээлийн үнэлгээ юм. Сайн эргэцүүлнэ гэдэг нь сайн уншсаны илэрхийлэл юм. Эргэцүүлж байгааг үнэлнэ гэдэг нь сайн уншсаныг л үнэлж байна гэсэн үг.

ДӨРӨВ: ҮНЭЛГЭЭ

КЕЙС:

Ээлжит хичээлийн үнэлгээ болон шалгуурыг зорилттойгоо хэрхэн холбож томъёолоход бэрхшээлтэй байна.

Зөвлөмж 1 Нэгж болон ээлжит хичээлийн зорилго, зорилт тодорхой болсон тохиолдолд үнэлгээ хийхэд хялбар болно. Ээлжит хичээлийн зорилго үнэлэгдэхүйц тодорхой байх, суралцахуйн зорилтын цаана хүүхдийн үйл ажиллагаа, үнэлгээний шалгуур байгааг тооцож судлах, хүүхдийн хийх үйл ажиллагааг хэдэн ширхэг, агуулгын ямар багтаамжтай ажлын хуудас хийхээ төлөвлөх, төлөвлөхдөө хичээлийн зорилт дээр үндэслэх, сурагч өөрийгөө үнэлэх боломжийг тусгах, үнэлгээний шалгуур боловсруулах, сурагч өөр хоорондоо ярилцах, хэлэлцэх, мэтгэлцэх зэргээр хичээлд оролцох бүтээлч эрэл хайгуулыг багш хийх зэргээр ээлжит хичээлээ төлөвлөвөл сурагчдын суралцахуйг дэмжсэн үнэлгээ бүхий хичээл бий болно.

Ахлах ангийн хөтөлбөрт мэдлэг, чадвар, хандлагыг үнэлнэ гэж тодорхойлсон тул нэгжийн төлөвлөлтөөсөө харж, хэдэн нэгж үзсэний дараа ямар мэдлэг, чадвар эзэмшсэнийг, хандлага нь хэрхэн тогтсоныг багш нар багаараа ярилцан үнэлгээний даалгавар боловсруулна. Тухайлбал, тайлбарласан эсээ, хөрөг найруулал, уран зохиолын эхийг уншихдаа сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх чадварыг эзэмшүүлэхээр эхний ээлжит хичээл бүрд тусгах нь зүйтэй. Сурагчдын онцлогоос шалтгаалж, хүүхэд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо хангалттай илэрхийлж сурч байна гэж багш явцдаа харж, үнэлж байгаа бол менежерт санал болгох, эсвэл секцээрээ үнэлгээний даалгавар боловсруулж болно. Жишээ нь, “Зохиолыг уншаад, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх” суралцахуйн зорилтыг үнэлэхдээ “Д.Нацагдоржийн “Харанхуй хад” зохиолыг уншуулна.

Шалгалтын хуудасны жишээ:

Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлнэ үү.	Сурагчийн хариулт	Хариулж бичихэд бэрхшээлтэй зүйл юу байв?
Аль хэсэгт сэтгэл чинь хөдөлж байна вэ? Яагаад?		
Зүүдний хэсгээс юу мэдрэв?		
Айдас төрж байв уу? Эсвэл сонирхолтой байсан уу? Яагаад?		
Зохиолчийн бичлэгт үзэл бодлоо илэрхийлнэ үү?		

Үнэлгээний хуудас: Сурагч зохиолоос мэдэрснээ бичихдээ:

/Унших чадварыг бичих чадвартай уялдуулж үнэлэхээр бол/

Мэдэрснээ илэрхийлэхдээ жишээ татаж байвал	2 оноо
Уншихад ойлгомжтой байвал	3 оноо
Үгийг олон удаа давтаагүй байвал	4 оноо
Зөв бичгийн дүрмийн алдаагүй байвал	5 оноо \Хэд алдвал хэдэн оноо авах вэ зэргээр онооны хувилбарыг багш нарийвчилж болно\

Жич: Ангийн сурагчдын найруулах чадвар сайн байвал заавал үнэлгээний шалгуур болгож авах шаардлагагүй. Үнэлгээний шалгуурыг гаргахдаа нэг талаас суралцахуйн зорилт буюу хүрэх үр дүнд суурилан тогтоохоос гадна сурагчдын ерөнхий чадвараас баримжаалж сонголт хийж болно.

Үнэлгээний хуудас: Сурагч зохиолоос мэдэрснээ ярихдаа:

/Унших чадварыг ярих чадвартай уялдуулж үнэлэхээр бол/

Мэдэрснээ илэрхийлэхдээ жишээ татаж байвал	2 оноо
Ярихдаа ойлгомжтой байвал	3 оноо
Ярьж илтгэхдээ дохио зангааг зөв хэрэглэж байвал \илүү хөдөлгөөн хийх эсэхэд багш анхаарна\	4 оноо
Харилцагчийнхаа онцлогт тохируулан ярьж байвал	5 оноо

Жич: Ангийн хүүхдүүд өмнөх нэгжээр ойлгомжтой ярих чадварыг хангалттай эзэмшсэн гэж үзвэл өөр ярих чадварыг сонгон үнэлгээгээ хийж, хичээл бүр дээр эзэмшүүлэхийг зорьж ажиллах нь зүй. Үнэлгээний хуудсыг сурагч өөрийн суралцахуйг үнэлэх зорилгоор хэрэглэж болно.

ТАВ: ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

КЕЙС:

- Сурах бичиг, багшийн ном байхгүй.
- Уран зохиолын агуулгаар судлах зохиол ховор. Сургуулийн номын санд нэг хоёр байдаг ч нийт хүүхдэд хэрхэн хүргэх нь бэрхшээлтэй.
- Монгол хэлний хичээл дээр задлан тайлбарлах эсээний нэр хэрэгтэй байна.
- Монгол бичгийн хөтөлбөрт шинээр орсон уран бичлэгийн элдэв тигүүд олдохгүй байна.

Зөвлөмж 1 Уран зохиолын эх сонголтын хувьд цөм хөтөлбөрт тодорхой заасан тул бэрхшээл бага байна. Харин олдоц, хүртээмж муу байгаа тул эх зохиолыг эмхэтгэж хэвлүүлэх ажил шаардлагатай байна. Дараах санал болгож байгаа ном, эмхэтгэлүүдийг хэрэглэж болно.

- Ч.Жачин “Д.Нацагдорж” 2015 он
- Ч.Оюунгэрэл, С.Оюунгэрэл “Уран зохиолын унших бичиг” 2016 он
- Д.Отгонсүрэн “Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулгын онцлог” 1983 он

Зөвлөмж 2 Сурагчдаар уншуулж, задлуулан, дүгнэлт гаргаж болох эсээний нэрс:

- До.Цэнджав Буурал ээжийхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ.
- Л.Өлзийтөгс Үзэхийн хязгаар
- Л.Түдэв 17,18 дугаар боть
- Б.Ганбат Эх
- П.Батхуяг Залбирлын эсээс
- Д.Цоодол – Хонины боол
- Д.Урианхай – Ээж минь
- О.Мэнд-Ооёо – Алтан - Овоо

Зөвлөмж 3 Хөтөлбөрт орсон монгол бичгийн тигүүдийн төрөл зүйл, жишээг “МХУЗ сургалт” facebook хаягтай холбогдож татаж авна уу. Мөн энэ хуудсаас хөтөлбөрийн агуулга, арга зүйтэй холбоотой зөвлөмжийг унших болон өөрийн тодруулах асуултад хариу авч болно.

Мөн <http://boditchadvarnbg.blog.gogo.mn/> хаягаар орж мэргэжлийн холбогдолтой мэдээлэлтэй танилцаж болно.

ЗУРГАА: ХАВСРАЛТ

Жишээлж, заавал судлах хөтөлбөрийн зорилтууд нь хэд хэддүгээр ангид хэрэгжихийг дараах байдлаар харьцуулж харвал:

		Хөтөлбөрийн зорилт	10 анги	11 анги	12 анги	
мэдлэг	МОНГОЛ ХЭЛ	Өгүүлбэрийн гишүүд ба үгсийн аймаг, гишүүдийн бүтэц, хэлбэржилт, байр, үүрэг				
		Нийлмэл өгүүлбэр, тэдгээрийг холбох хэрэглүүр (гадаад ба дотоод холбоос)				
		Орон, цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэр				
		Үг, өгүүлбэр, цогцолборыг холбох задлаг ба нийлэг арга				
		Уран илтгэх зүй				
		Аман ба бичгийн найруулгын зэрэг, баймж - өнгө аяс				
		Өвөрмөц, хэвшмэл хэлц				
		Уран дүрслэл, яруу хэрэглүүр				
		Толь бичгийн зориулалт, төрөл, бүтэц, ашиглах арга				
	Үндэсний	Түүхэн ба хуучин үг хэллэг, түүхэн бүтээвэр				
		Хүндэтгэлийн үг хэллэг				
		Монгол бичгийн ялгах ёс				
	Уран зохиол	Зохиолын сэдэв, утга, хам сэдэв				
		Уянга, туульс, жүжгийн зохиолын шүлэглэсэн ба үргэлжилсэн үгийн хэлбэр, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг				
		Уран зохиолын хэл, найруулгын онцлог				
	чадвар	Монгол хэл	Бичгийн найруулгын төрөл, тэдгээрийн бүтэц, агуулга, санаа, хэл найруулгад дүгнэлт гаргах			
			Ярианы соёл, баймж, өнгө аясыг тодорхойлох, дүгнэлт гаргах			
			Зорилго, уншигч ба сонсогч, нөхцөл байдлын онцлогт тохирсон бүтэц, найруулгын төрөл, хэв маяг, үг, өгүүлбэрийг сонгон ярих, бичих			
Мэдээлэлтэй ажиллах арга барилаа ашиглан бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээгээ хөгжүүлэх						
Үнд		Монгол бичгээр зөв, хурдан, уран тод унших				

		Монгол бичгээр алдаагүй, хичээнгүй бичих			
	Уранзохиол	Зохиолын агуулга, утга санааг ойлгох, зохиол дахь түүх, нийгэм, соёлын хам сэдвийг тусган эргэцүүлэх			
		Зохиолын төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэх			
		Зохиолын хэлний хэрэглээг тайлбарлах			
		нийт	18	18	18

Б. Монгол хэл, уран зохиол, монгол бичгийн хичээлийн нэгдмэл хөтөлбөр 10 дугаар анги Заавал судлах 2016 он
(Жишээ)

Нэгж	Сэдэв	Цаг	Унших	Бичих	Ярих
Нэгж 1	Ажлын удирдамж	8	1. Ажлын удирдамжийг уншиж, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах 2. Ажлын удирдамжид албаны үг хэллэг сонгосон зорилгыг тайлбарлах 3. Зэрэгцүүлэх, үүрэгтэй бүтээвэр, холбох үгийн найруулгын үүргийг тайлбарлах	1. Загварт найруулгын бүтэц, онцлог, агуулгын уялдаа холбоог гаргаж тоочин бичих	
Нэгж 2	Тайлан	8	1. Тайланг уншиж, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах 2. Тайланд албаны үг хэллэг сонгосон зорилгыг тайлбарлах 3. Зэрэгцүүлэх, үүрэгтэй бүтээвэр, холбох үгийн найруулгын үүргийг тайлбарлах 4. Өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт, утга байрыг тодорхойлох, эхийн найруулгад гүйцэтгэж байгаа үүргийг тайлбарлах	1. Загварт найруулгын бүтэц, онцлог, агуулгын уялдаа холбоог гаргаж тоочин бичих 2. Тайлангийн бүтцийн хэсгийг сонгон үндэсний бичгээр бичих 3. Бичсэн тайлангаа хурааж бичих	
Нэгж 3	Хөрөг найруулал	14	1. Хөрөг найрууллыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Хөрөг найрууллын сэдэв, агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах 3. Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах 4. Хөрөг найрууллын уран дүрслэл, хэлц, яруу хэрэглүүрийн уншигчдад үзүүлэх үр нөлөөллийг тайлбарлах 5. Хөрөг найрууллын гадаад ба дотоод орчин нь баатрыг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 6. Зохиолын найруулга нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 7. Зохиолын хэлний хэрэглээ, уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах	1. Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ баримтад тулгуурлан дүрслэн бичих 2. Идэвхтэй хэрэглээ бүхий үгсийн үндэс, залгаврыг үндэсний бичгээр зөв бичих	1. Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, уран дүрслэл зэргийг ашиглан илэрхийлэх
Нэгж 4	Тайлбарласан эсээ	16 цаг	1. Тайлбарласан эсээг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Тайлбарласан эсээний сэдэв агуулгын уялдаа холбоо, дарааллыг тайлбарлах 3. Эхэд зохиогчийн ашигласан баримтад дүгнэлт гаргах 4. Угсруулах үүрэгтэй бүтээвэр, холбох үгийн найруулгын үүргийг тайлбарлах	1. Олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих 2. Задалсан эсээгээ баримтаар дэлгэрүүлж бичих	1. Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, эшлэл зэргийг ашиглан илэрхийлэх

Нэгж 5	Баримтад үндэслэн бичих	14 цаг		<ul style="list-style-type: none"> 1. Тайлан бичих (Тоочин бичих) 2. Эсээ бичих (Тайлбарлан бичих) 3. Хөрөг бичих (Дүрслэн бичих) 	
Нэгж 6	Үндэсний бичиг	10 цаг	<ul style="list-style-type: none"> 1. Сонгодог бичгийн бүтээлээс уншиж, утгыг тайлбарлах 2. Түүхэн, хуучирсан, шинэ үг хэллэгийг таних, бичлэг, утгыг тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> 1. Сонгодог бичгийн зохиол бүтээлээс сонгож бичих 2. Түүхэн болон хуучирсан үг хэллэгийн тайлбар толь хөтлөх 3. Идэвхтэй хэрэглээ бүхий үгсийн үндэс, залгаврыг зөв бичих 4. Сонгодог бичгийн зохиол бүтээлээс үндэсний бичгээр хурааж бичих 	
Нэгж 7	Уянгын зохиол	12 цаг	<ul style="list-style-type: none"> 1. Үндэсний бичгээр болон орчин цагийн монгол хэлээр бичсэн яруу найргийг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах 3. Далд утгыг тайлан тайлбарлах 4. Яруу найргийн эгшиглэл, бадаглалын онцлогийг тайлбарлах 5. Зохиолын уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах 6. Угсруулах үүрэгтэй бүтээвэр, холбох үгийн найруулгын үүргийг тайлбарлах 7. Эсрэг, ойролцоо утгатай үг, бүтээвэр, өгүүлбэрийн утгыг ойлгох, хэрэглэх 	<ul style="list-style-type: none"> 1. Зохиолын хэл, найруулгаас үлгэрлэн санаагаа уран сайхнаар илэрхийлэх 2. Уянгын зохиолоос сонгож үндэсний бичгээр бичих 	1.Зохиолыг уран сайхнаар унших

Нэгж 8	Өгүүллэг	12	<ol style="list-style-type: none"> 1. Үндэсний бичгээр болон орчин цагийн монгол хэлээр бичсэн өгүүллэгийг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах 3. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлаж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах 4. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 5. Далд утгыг тайлан тайлбарлах 6. Өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт, утга байрыг тодорхойлох, эхийн найруулгад гүйцэтгэж байгаа үүргийг тайлбарлах 7. Бичгийн найруулгын зэргийг ялгах 	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын хэл, найруулгаас үлгэрлэн санаагаа уран сайхнаар илэрхийлэх 2. Өгүүллэгийн өгүүлэгдэхүүний бүтцээс сонгон дэлгэрүүлэн бичих 	1. Зохиолыг уран сайхнаар унших
Нэгж 9	Роман	12 цаг	<ol style="list-style-type: none"> 1. Түүхэн романыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлаж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах 3. Зохиолын дүрийн бодит ба хийсвэр шинжийг тодорхойлж, зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах 4. Зохиолын уран дүрслэл, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах 5. Эсрэг, ойролцоо утгатай үг, бүтээвэр, өгүүлбэрийн утгыг ойлгох, хэрэглэх 	Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, жишээ баримтаар тайлбарлах	

Нэгж 10	Монголын нууц товчоо	12	<ol style="list-style-type: none"> 1. Монголын нууц товчоо зохиолыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах 3 Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлаж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах 4 Зохиолын дүрийн бодит ба хийсвэр шинжийг тодорхойлж, зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах 5.Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 6.Зохиолын найруулга нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 7.Зохиолын хэлний хэрэглээ, уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг тайлбарлах 	<ol style="list-style-type: none"> 1.Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, жишээ баримтаар тайлбарлах 2. Монголын нууц товчооны хэсгээс сонгож үндэсний бичгээр бичих 	<ol style="list-style-type: none"> 1.Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ уран дүрслэл, хэлц зэргийг ашиглан илэрхийлэх
Нэгж 11	Жүжгийн зохиол	10	<ol style="list-style-type: none"> 1.Жүжгийн зохиолыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх 2. Зохиолын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах 3.Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 4. Далд утгыг тайлан тайлбарлах 5. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох 6. Бичгийн найруулгын зэргийг ялгах 	<ol style="list-style-type: none"> 1.Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, жишээ баримтаар тайлбарлах 	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолыг уран сайхнаар унших 2. Зорилго, нөхцөл байдал, харилцагчийн онцлогт тохируулан ярих
Нэгж 12	Бичих, ярих	12		Олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан ярих, бичих	

В. Баримтад дүн шинжилгээ хийх ажлын хуудас

Асуулт	Жишээ
Баримтын үнэн эсэхийг нотлох Баримтад тавигдах үндсэн шаардлага - ҮНЭН” байх.	
Баримт олсон эх сурвалжаа бичнэ	
Баримтын эх сурвалж буюу нэмэлт тайлбар хийх тохиолдолд зүүлт хийдэг. Таны цуглуулсан баримтад зүүлт байсан уу. Байсан бол яаж хийсэн, үгүй бол яагаад?	
Шууд ба шууд бус ажиглалтын баримт	Шууд ажиглалтын: Мэдээллийг харах сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх зэрэг 5 мэдрэхүйгээр олж авсан авсан Шууд бус ажиглалтын: Ном зохиол бичиг баримт зэргээс дам олж авсан
Баримт	Баримтын мэдээлэл: Тухайн өгүүлж байгаа зүйлтэй холбогдсон үзэгдэл үйл явдлын тухай бодит мэдээлэл. Үзэл бодлын мэдээлэл: Баримтын мэдээллийг харьцуулан ажиглаад зохиогчид төрсөн санаа, түүний хувийн ухаарал дүгнэлт
Баримт	Баримт сонирхолтой байх Тухайн асуудалд олон нийтийн анхаарлыг татах, сурталчлах, уриалах, дагуулахаар. Үр дүн, ач холбогдолтой байх Учир шалтгааныг нотлох, үнэн, хөдөлшгүй, хамгийн оновчтой.
Баримтад юу юуг хамруулж болох вэ?	Баримтад юу юуг хамруулж болох вэ? Таны баримтын төрөл
	Судалгаа шинжилгээний баримт, статистик тоон мэдээлэл...

Г. Тайлбарласан эсээгээр задлах эх: Хурд нэмэх жам Л.Түдэв

Хурдаа нэмэх жамаар хүн төрөлхтөн хөгжиж байна. Энэнээс өөр жам ёс түүнд үгүй юм. Хөгжлийн энэ хурд сүүлийн үед өөрт нь захирагдахгүй шинжтэй болж байна. Урьдчилан тооцоолоход ч ухаан хүрэхгүй тохиолдол улам олширлоо. Яарамгүй тайван амьдарч байсан эрт балрын цагтай харьцуулбал өнөөдөр манай Хурд толгой эргэм түргэн боллоо.

Хүн төрөлхтний анхны үеийн хүмүүс агуйд амьдарч өнгөрчээ. Дараах нь агуйгаас гарч гэр, байшинд орж морь унадаг болсноосоо хойш хурдаа улам бүр нэмсээр одоо нэгэнт зогсоон барих юм уу, сааруулах аргагүй хэмжээнд хүрчээ.

Өнгөрсөн зуунд галт тэрэг бий болж хүний хурдлах чадварт өөрчлөлт гарчээ. Гэтэл тийм хурданд дасаагүй байсан хүмүүсийн нүд эрээлжлэн толгой нь эргэж нэг хэсэгтээ сандарчээ. Германы Баварийн анагаах ухааны коллеги галт тэргээр хурдлан явах нь хүний эрүүл мэндэд хортой гэж үзээд эсэргүүцлийн акт бичиж түүндээ “ийм хурдаар явбал зорчин явагсдад тархины өвчин, солиорон халуурахын онцгой нэг төрөл зүйл гэм үүснэ” гэсэн дүгнэлт гаргажээ.

Түүнээс болж галт тэргэнд суух хүн олдохгүй нэг хэсэг хугацаа өнгөрчээ. Гэвч сониуч эрс мундахгүй энэ дэлхийд галт тэрэг тун удалгүй олны хөл залгуулах хамгийн түгээмэл унаа болсон ажээ. Солиорон халуурч, тархи нь гэмтсэн хүн ч гарсангүй. Гэвч хурднаас айх айдас хүнээс тийм ч амархан салаагүй юм.

Туузан нэхмэлийн машин зохион бүтээсэн Данцингийг боймолж алаад бүтээлий нь нуучихсан шигээ одоогийн цахилгаан эрчим хүчний эцэг дизель мотор зохиосон Дизелийг тэнгист живүүлж, уусдаг кофе бодож олсон Либихийн жорыг зуугаад жил нуун дарагдуулсан гунигт түүх бий билээ. Гараар нэхэх хурдыг хэдэн арав дахин нэмсэн Данцингийн машин, бүхий л техникийн хурдыг зүйрлэшгүй нэмсэн Дизель мотороом эхлээд ядаж цай чанах хурдыг хэд дахин түргэтгэсэн уусдаг кофег хурднаас нь айж тийнхүү нууж хаагаагүйсэн бол хүн төрөлхтөн өнгөрсөн зуунд их л цаг хожих байлаа.

Түүний нэгэн адилаар хөвөн хураах машин, усан компас тэргүүтнийг амьдралд нэвтрүүлэх гэж тавин жил хөөцөлдсөн бол цахилгаан товчийг хорин жил, өөрөө түлхэгддэг цагийг ердөө л зургаахан жилд хүмүүсийн ахуйн хэрэгцээнд оруулжээ.

Наашлах тусмаа амьдралд нэвтрэх хугацаа нь богиносож байгаа шинэ бүтээлүүд хүний хөдөлмөрийн хурдыг улам түргэсгэж байна. Товчоо товчлох, цагаа түлхэхэд нүд ирмэх төдий цаг зарж байгаа нь үнэндээ хурд нэмэх жамаар явж байгаагийн шинж мөн.

Хорьдугаар зуун хүн төрөлхтөнийг жигүүртэй юм шиг хурдтай болгож өглөө. Сүүлийн зуун жилд харилцаа холбооны хурд 10 сая дахин, зорчин явах хурд зуу дахин, мэдээлэл тэмдэглэх хурд мянга дахин, эд бараа үйлдвэрлэлийн хурд зуу дахин, зэвсэг үйлдвэрлэх хурд нэг сая дахин тус тус нэмэгджээ. Энэхүү цөөн тоо хүн төрөлхтөний тухай олон талын тодорхойлолт өгч байна. Эд бараа үйлдвэрлэх хурд зуугаадхан дахин нэмэгдсэн байхад зэвсэг үйлдвэрлэх хурд нэг сая дахин өсчээ. Хурдан бүтээх, хурдан явах, хурдан ажиллахыг хүн хүсдэг боловч бас хурдаас айдаг зантан, түүнээсээ ч аажмаар салсаар байна.

Монголын ард түмний тухайд бол түүхийн хөгжлийн нэгэн өвөрмөц хурдыг сонгож авснаас хойш цөөн бус жил өнгөрлөө. Нийгмийн хөгжлийн бүхэл бүтэн хэвшлийг алгасаж хурдавчилсан аргаар хөгжих замыг манай ард түмэн сонгож авсан юм. Морь л хамгийн хурдан унаа гэгдэж байсан монгол оронд моторт техник шууд нэвтэрсэнчлэн үйлдвэрлэлийн хөгжлийн хамтлагийн аргыг хэрэглэх болсны дүнд ердийн хурдаа ч, нийгмийн хурдцаа ч монгол хүн хэдэн арав зуу дахин нэмж чадлаа. “Зууныг нягтруулсан арван жилүүд” гэж манай хөгжлийн жилүүдийг дэлхий дахинд нэрлэж байв. Үнэний хувьтай энэ үгийн цаана манай хурдны хэмжүүр харагдаж байна. Энэ зууны эхэнд монгол хүн юу хийж чаддаг байлаа? Арьс элдэж, дээс томж, дарх хийдэг байлаа. Гэр барьж, эсгий хийж, сүм байгуулж, бурхан бүтээж байлаа. Морин өртөөгөөр албаа залгуулж, үхэр тэргээр ачаагаа зөөж, тэмээн жингээр “экспорт, “ импортоо” татаж, хүргэж байлаа. Одоо бид юу бүтээж байна вэ. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, цөмийн шинжилгээ хийж, электрон багаж бүтээж, автомашин барьж, нисэх онгоц жолоодож, галт тэрэг эзэмшиж байна. Бүхэл бүтэн хот, үйлдвэр, уурхай байгуулж, хүдэр олзворлож, засмал болоод төмөр зам тавьж усан замаар онгоц жолоодож байна. Дуунаас хурдан нэсэх онгоц, орчин үеийн Белаз машин аль нь ч монгол хүний гарт морь шиг эдлэгдэж трактороор газраа хагалж комбайнаар тариагаа хадаж, төрөл бүрийн техникээр хивсээ нэхэж номоо хэвлэж, ноосон эдлэл, илгэн дээлээ үйлдвэрлэж байна. Энэ нь ердийн хэрэг болж ээрүүл, тээрмийн чулуу,

тулман хөөрөг цөм л музейд тавигдаад байна. Ээрүүлээр утас ээрэх нь битгий хэл “ээрүүл” гэдэг үгийг ч одоогийн зарим залуус мэдэхгүй шахам болжээ.

Хориод оны үед Дээд үд хотоос анхны нисэх онгоц монголын захиалгаар ирэхдээ зургаахан хүн авч, зургаа шахам цаг явж байж нийслэлд ирэхэд нь түүний хурданд гайхаж “төмөр шувуу” хэмээн нэрлэж, ихэнх хүн итгэхгүй болжээ. Гэтэл одоо тэр зайг ганц цаг хүрэхгүй хугацаанд туулж хоёр зуугаад хүн багтаасан тийрэлтэт хөлөг онгоцоор монголчууд зорчин явах боллоо. Баруун аймгаас мөргөлчид их хүрээ орохоор морь, тэмээгээр гараад хоёр сар шахам явж байж ирэхдээ “Хүрээ яасан хол юм бэ? Хүний амь яасан бөх юм бэ?” гээд уйлж байсан гэдэг. Тэгвэл одоо монгол улс бүрэн эрхт гишүүний нь хувьд Нэгдсэн үндэстний байгууллагын хуралд суухаар бөмбөрцгийн нөгөө бөөрөнд байгаа Нью Йорк орохоор явуулах төлөөлөгчөө нэг хоёр хоногийн дотор хүргэж чаддаг болжээ. Манай хурдны доод талыг хэмжихээс биш, дээд цэгийг тогтоох аргагүй болжээ. Учир нь хурд маань жил байтугай сарын дотор өөрчлөгдөж байна. Дэлхийн бөмбөрцгийг цаг гаруйхны дотор тойрно гэж тавхан жилийн өмнө буюу 1980 онд хэн нэг монгол хүн ярьсан бол түүнийг дэгсдүүлдэг хөөргөн эр гэж дооглох байсан. Гэтэл одоо монгол хүн нэгэнт тэр мэт хурдыг эзэмшиж дэлхийд сансрын нисэгчтэй арав гаруйхан орны нэгэнд багтан ороод байна. Сансарт нисэх тухай өчигдөрхөн болтол огт өөр юм бид ярьдаг байлаа. Гэтэл өнөөдөр дэлхийн сансрын 100 гаруйхан нисэгчийн нэг нь монголын иргэн болжээ.

Өнөөгийн манай хурдыг арав, хорь, гуч, дөчин жилийн өмнөхтэй зүйрлэх аргагүй болжээ. Дөч гаруй жилийн өмнө 1940 онд бид нэг өдөрт 31 мянга гаруйхан киловатт цагийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг байлаа. Гэтэл өнөөдөр 1985 онд дөрвөн сая долоон зуугаад мянган киловатт цагийн эрчим хүчийг ганцхан өдөрт үйлдвэрлэж байна. Дөчин онд таван мянган долоон зуун ширхэг тоосго өдөрт цохидог байсан бол 1985 онд 30-аад мянгыг гаргадаг болжээ. 1940 оны турш тээсэн ачааг одоо ажлын ганц өдөрт тээж байна. Энэчлэнгээр харьцуулан ярих юм бол манай ажил, амьдралын хурдыг хэмжихэд гайхалтай сонин тоо их гарах болно.

Ийм их хурдтай болчихоод байгаагаа сайн мэдрэхгүй аажмаар дасаж орхидог ч байж болох юм. Гэтэл үнэхээр толгой эргэмээр их хурд авч байгаа манай орны хөгжлийн зам нь нийгмийн давших хөдөлгөөнийг түргэсгэж болохыг харуулсан ховор хэмжээсийн нэг юм. Яагаад ийм их хурд авчав аа гэж хөндлөнгийн хүмүүс, өрнөдийн

монголч эрдэмтэд, сэтгүүлчид гайхаж нууцыг нь тайлахыг оролддог. Гэвч үүнд тусгай нууц байсангүй. Гагцхүү эрх чөлөөгөө олсон ард түмний чармайлт өндөр хөгжилтэй ах дүү хамтран ажилласны үр дүнд л хөгжлийнхөө хурдыг бид нэмж чадсан юм..Нийгмийн хөгжлийн ерөнхий хурд нь амьдрал ахуйн бүхий л салбар, салаа мөчрыг хамарч монгол хүн одоо алхаж гишгэх, ярих, бичихдээ ч хурдан боллоо.

Франц хүн минутад дундажаар 350 үетэй үг, япон хүн 310, герман хүн 250 үетэй үг хэлж амждаг гэж эрдэмтэд тооцоолж гаргасан юм. Тэгвэл монгол хүн энэ зууны эхээр минутад тийм олон үг хэлэх нь тун ч ховор тохиолдол байлаа. Гэвч өнөөдөр герман хүнээс дутахгүй олон үг минутад хэлдэг илтгэгч өдий төдий болжээ. Ярианы хурд нэмэгдэж байгаа нь сэтгэн бодохын хурд бас л өссөнийг илэрхийлнэ.. Бодлоо үг яриагаар илэрхийлдэг учраас өөрөөр байж болохгүй юм.

Манай хурд асар ихээр нэгэдсэн боловч нэг зүйл дээр хурд асар их буурлаа. Энэ бол амьдралын хугацаа! Зууны эхээр монголчуудын дундаж нас 35 байлаа. Төрөхөөс үхэхийн хоорондох хугацаа богино, өөрөөр хэлбэл, үхэл их хурдтай ирдэг байлаа. Өнөөдөр монгол хүний дундаж нас 65 боллоо. Амьдрах хугацаагаа удаашруулж, үхлийн хурдыг сааруулж байна. Энэ бол бидний бас нэг бахархал мөн.

Эх орныхоо дотор бид хөгжих, дэвших хурдаа нэмэхдээ энэ дэлхийн хөгжлийн нийт хурданд татагдан орж, түүнээс хоцрохгүйг хичээж байна. Хүн төрөлхтөн толгой эргэмээр, бүр төрсөн бие пянгий нь даахааргүй хурдтай шинэ зуун, хорин нэгдүгээр зууны босгон дээр ирлээ. Шинээр учран золгох зуун бол бүх төрлийн юмны хурдац асар их нэмэгдэх зуун, дууны хурдыг хэд нугалан түрүүлж, гэрлийн хурдыг ардаа хийгээд сэтгэлийн хурдыг давж гарах зуун юм. Үүнд бид үр хүүхдээ сэтгэл санаа, бие бялдраар бэлтгэх ёстой. Хурд биднийг хүлээхгүй. Хурд бол шинэ маягийн хувьсгалын гол утга, хөтөлбөргүй жам болно. 1985 он

Танд амжилт хүсье